



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх асуудлыг дэмжиж, гарын үсэг зурах эрхийг олгов.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б. ЭНХ-АМГАЛАН

БАЙНГЫН ХОРОО
ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ

Б. АНДИЙМАА

**ДЭЭД БОЛОВСРОЛД ХАМААРАХ ЭРДМИЙН ЗЭРГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ
ТУХАЙ ДЭЛХИЙ ДАХИНЫ КОНВЕНЦЫГ ЗӨВШИЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 03 дугаар
сарын 23-ны өдөр


Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар дээрх төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх асуудлыг дэмжсэн болно.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б. ЭНХ-АМГАЛАН